



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 11 сарын 06 өдөр

Дугаар 449

Улаанбаатар хот

“Мандал женерал даатгал” ХХК-ийн хувь
нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт
оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 21.3.2, 21.5, Компанийн тухай хуулийн 31.2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Мандал женерал даатгал” ХХК-ийн хувь нийлүүлэгч “Mongolia Growth Group Ltd” ХК-ийн өмчлөлийн нэг гирхэг нь 1,000.0 /нэг мянга/ төгрөгийн үнэ бүхий 6,243,016 /зургаан сая хоёр зуун дөчин гурван мянга арван зургаа/ ширхэг буюу 6,243,016,000.0 /зургаан тэрбум хоёр зуун дөчин гурван сая арван зургаан мянга/ төгрөгийн хувьцаанаас 1,243,016 /нэг сая хоёр зуун дөчин гурван мянга арван зургаа/ ширхэг буюу 1,243,016,000.0 /нэг тэрбум хоёр зуун дөчин гурван сая арван зургаан мянга/ төгрөгийн хувьцааг “Мандал женерал даатгал” ХХК-д худалдаж, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд дараах байдлаар өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь /%/
		Эхний үлдэгдэл	Өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	
1	“Mongolia Growth Group Ltd.”ХК	6,243,016,000.0	(1,243,016,000.0)	5,000,000,000.0	80,09
2	“Мандал женерал даатгал” ХХК	0.0	1,243,016,000.0	1,243,016,000.0	19,91
	Нийт	6,243,016,000.0	0.0	6,243,016,000.0	100

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2013 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Мандал женерал даатгал” ХХК /М.Давааням/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Х.Бум-Эрдэнэ
Ажлын алба